### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Заг сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж аудитын менежер А.Цээням, Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Заг сумын сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 16-ний өдрийн 1/07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Заг сумын Засаг даргын 1 дүгээр гарын үсгийг Засаг дарга Т.Нямжаргал, 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны дарга Д.Дуламсүрэн нар зурж байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Заг сумын Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Орон нутгийн бие даан хөгжих боломжийг бүрдүүлж эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, хүний хөгжил, язгуур эрх ашиг, өв соёл ёс заншлаа эрхэмлэн дээдэлж, төрийн үйлчилгээнд иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, айл өрх бүр ажил орлоготой, байгалийн тэнцвэрт байдлыг хангасан хөгжингүй эдийн засагтай үйлдвэрлэгч сум болно” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйг хөгжүүлэх
- Газар тариаланг хөгжүүлэх
- Нийтийн аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- Байгаль хамгаалах хөтөлбөр
- Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх
- Төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, сургалт сурталчилгаа
- Сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх
- Монгол улсын Засгийн газраас Боловсрол Соёл, Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
- Иргэдийн оролцоог хангах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Заг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Заг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 70 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 998,040.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9,980.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,986.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.5.1. Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 391353,0 мянга, эцсийн үлдэгдэл 784414,3 мянган төгрөг болж 393064,3 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө	391353,0	784414,3	393064,3	100
<b>Дүн</b>	<b>391353,0</b>	<b>784414,3</b>	<b>393064,3</b>	<b>100</b>

*Эх сурвалж: Заг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 784414,3 мянган төгрөг нь төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын дансанд буцаан төвлөрүүлсэн 62312,1 мянга, Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 74537,2 мянга, Сум хөгжүүлэх сангийн дансанд 27185,5 мянга, орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 620379,5 мянган төгрөг байршиж байна.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 289749,6 мянга, эцсийн үлдэгдэл 185326,8 мянган төгрөг болж 104422,8 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 2. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
----------	----------------	-----------------	------------------------

Заг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Ажиллагсадтай холбогдсон авлага	156,2	-	(156,2)
Татаас санхүүжилтын авлага	180195,1	-	(180195,1)
Байгууллагаас авах авлага	1000,0		(1000)
Хувь хүмүүсээс авах авлага	1009,0	18509,0	17500
Хувь хүмүүст олгосон зээл	107389,2	166817,8	59428,6)
Хувийн хэвшлийн аж ахуй нэгжид олгосон зээл			-
<b>Дүн</b>	<b>289749,6</b>	<b>185326,8</b>	<b>-100422,8</b>

Эх сурвалж: Заг сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 90 хувь буюу 166817,8 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн авлага, 10.4 хувь буюу 18509,0 мянган төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн авлага байна.

*Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засаг даргын Тамгын газар	19,4		-19,4	0
ИТХ	75,0		-75,0	0
Соёл	0		0	0.0
ЭМТ	180195,1		-180195,1	0
СХС	107389,2	166817,8	59428,6	90,0
Цэцэрлэг	0			0.0
ЕБС	61,8		-61,8	0
ОНХСан	2009,0	18509,0	17500,0	10
<b>НИЙТ ДҮН</b>	<b>289749,6</b>	<b>185326,8</b>	<b>-100422,8</b>	<b>100.00</b>

Эх сурвалж: Заг сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сум хөгжүүлэх сангийн авлага оны эхэнд 107389,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тус онд 6 иргэнд 86000,0 мянган төгрөгийн зээл олгож тус сангийн үйл ажиллагааны зардалд 1450,0 мянган төгрөг зарцуулсан бөгөөд 29338,4 мянган төгрөгийн авлагыг барагдуулж оны эцэст 166817,8 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэлтэй байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 246412,3 мянга, эцсийн үлдэгдэл 79640,1 төгрөг болж, 166772,2 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	161827,9	37641,5	-124186,4
Эм боох материал	12354,3	0	-12354,3
Бичиг хэргийн материал	1095,9	1272,3	176,4
Аж ахуйн материал	18938,1	3267,8	-15670,3
Сэлбэг хэрэгсэл	453,4		-453,4
Түлш, шатах тослох материал	0		0
Барилгын засварын материал	0	4000,0	4000,0
Хүнсний материал	1674,2	0	-1674,2
Бусад хангамжийн материал	23338,0	13981,1	-9356,9
Мал амьтад			0
Нөөцийн бараа	26730,2	19477,9	-7252,3
<b>Дүн</b>	<b>246412,3</b>	<b>79640,1</b>	<b>-166772,2</b>

Эх сурвалж: Заг сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 79640,1 мянган төгрөг болж өмнөх оноос 166772,2

Заг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

мянган төгрөгөөр буурсан Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, хүүхдийн цэцэрлэг, соёлын төв нь улсын төсвийн байгууллага болсонтой холбоотой тухайн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдэхгүй болсонтой холбоотой байна.

*Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	,3590,9	3680,7	89,8	4,6
ЗДТГ	69167,7	71244,6	2076,9	89,5
Соёл	11121,6		(11121,6)	-
ЭМТ	43384,0		(43384,0)	-
ОНХС	4714,8	4714,8	0	5,9
ЕБС	67975,2		(67975,0)	-
Цэцэрлэг	46457,3		(46457,3)	-
<b>НИЙТ ДҮН</b>	<b>246412,3</b>	<b>79640,1</b>	<b>-166772,2</b>	<b>100,0</b>

*Эх сурвалж: Заг сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд нийт нэмэгдсэн 159004,2 мянган төгрөгийн бараа материалын 95439,3 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 63564,9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна. Мөн нийт хасагдсан 325776,4 мянган төгрөгийн 168940,7 мянган төгрөг буюу 68,5 хувь нь шилжүүлсэн бүтцийн өөрчлөлттэй холбоотой байна.

*Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

Нэмэгдсэн	159004,2	Хасагдсан	325776,4
Худалдан авсан	95439,3	Худалдсан, зарцуулсан	156835,7
Хандиваар		Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	0
Шилжүүлсэн авсан	63564,9	шилжүүлсэн	168940,7
бусад		бусад	0

*Эх сурвалж: Заг сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6418475 мянга, эцсийн үлдэгдэл 1847580,6 мянган төгрөг болж 3951630,1 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>БИЕТ ХӨРӨНГӨ</b>	<b>6367705,9</b>	<b>1809587,5</b>	<b>--4558118,4</b>	<b>97,9</b>
Барилга байгууламж, орон сууц	4579851,8	742754,1	--3837097,7	40,2
Тээврийн хэрэгсэл	154184,8	140804,8	-13380,0	7,6
Машин тоног төхөөрөмж	667788,4	382047,2	--285741,2	20,6
Тавилга эд хогшил	142222,2	37816,3	-104405,9	2,0
Дуусаагүй барилга байгууламж	198105,4	0	-198105,0	0,0
Номын фонд	22597,4	1135,0	-21462,4	0,1
Бусад үндсэн хөрөнгө	602955,9	505030,1	-97925,8	27,3
<b>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</b>	<b>50769,1</b>	<b>37993,1</b>	<b>-12776,0</b>	<b>2,1</b>
Программ хангамж	3842,5	2300,0	-1542,5	0,1
Бусад биет бус хөрөнгө	48186,0	36264,0	-11922,0	2
<b>НИЙТ ДҮН</b>	<b>6418475,0</b>	<b>1847580,6</b>	<b>--3951630,1</b>	<b>100,0</b>

*Эх сурвалж: Заг сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Заг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тайлант онд Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, соёлын төвийн байгууллагууд улсын төсвийн байгууллага болсонтой холбоотой шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр 4647419,1 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

*Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	17507,0	16553,7	-953,3	0,8
ЗДТГ	1754808,4	1831597,8	767894,0	99,2
Соёл	1794603,4		-1794603,4	0,0
ЕБС	1313415,1		-1313415,1	0,0
Цэцэрлэг	496696,0		-496696,0	0,0
Эмнэлэг	1092704,5		-1092704,5	0,0
ОНХСан			0,0	0,0
<b>НИЙТ ДҮН</b>	<b>6419734,6</b>	<b>1848151,5</b>	<b>--4571583,1</b>	<b>100.061</b>

Эх сурвалж: Заг сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 473451,2 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний 44,3 хувь буюу 209997,1 мянган төгрөгийг хөрөнгийн үнэ төлбөргүй шилжүүлэн авсан нь голлох нөлөө үзүүлж байна

*Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

Нэмэгдсэн	473451,2	Хасагдсан	5045034,2
Худалдан авсан	95828,0	Худалдсан	
Хандиваар	0.00	Акталсан	199509,7
Шилжүүлэн авсан	209997,1	Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	4647419,1
бусад	167629,1	Бусад	198105,1

Эх сурвалж: Заг сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.8 Өр төлбөр байхгүй

#### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6046134,9 мянга, эцсийн үлдэгдэл 2216371,2 мянган төгрөг болж, 3829763,7 мянган төгрөгөөр төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 12. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВИЙ ОРОЛЦОО /МЯНГАН ТӨГРӨГ/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1483681,1	544528,0	(939153,1)	14.3
Өмч: - төрйн			-	-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2743005,7</b>	<b>1351913,3</b>	<b>(1391152,4)</b>	<b>80.2</b>
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1819448,0	319929,8	(1499518,4)	5.5
<b>Дүн</b>	<b>6046134,9</b>	<b>2216371,2</b>	<b>(3829763,7)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Заг сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 3829763,7 мянган төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, соёлын төвийн байгууллагууд бүтцийн өөрчлөлтөөр тухайн тайлант нэгтгэгдээгүйтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.10 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2021.12.20-ны өдрийн хуралдаанаар 05/10 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 160300,0 мянга, хүү торгуулийн орлогыг 5,000.0 мянга, нийт 165300.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	160300,0	719999,9	559699,9	449
ЦХТА рлого /суутган/	72000,0	99293,0	27293,0	138
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	1000,0	751,9	-248,1	75
Бууны татвар	2000,0	1920,0	-80,0	96
ИОТХ	20000,0	13010,8	-6989,2	65
Улсын тэмдэгтийн хураамж	1500,0	582,2	-917,8	39
Хадгаламжийн хүүгийн орлого	32000,0	21127,4	-10872,6	96
Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого	3,000.0	882,2	-2117,8	29
Малын тоо толгойн албан татвар	20000,0	19982,2	-17,8	99
Газрын төлбөр	2800,0	1593,1	-1206,9	57
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	6,000.0	3419,4	-2580,6	57
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	-	557437,4	557437,4	557
ТТАМАТөлбөр	0	0	0	0
Ойн нөөц ашигласны төлбөр	-	0	0	0
2.Татварын бус орлого	5,000.0	7660,0	2660,0	153
2.1.Хүү торгуулийн орлого	5000.0	7660,0	2660,0	153
<b>Нийт дүн</b>	<b>165300,0</b>	<b>727659,9</b>	<b>562359,9</b>	<b>440</b>

Эх сурвалж: Заг сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 440 хувь буюу 562359,9 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 27293,0 мянга, хүү торгуулийн орлогыг 153 хувь буюу 2660,0 мянган төгрөгөөр,, ан амьтны нөөц ашигласны төлбөр 557437,4 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна. Харин бууны албан татвар 80,0 мянга, улсын тэмдэгтийн хураамж 917,8 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 10872,6 мянга, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого 2117,0 мянга, малын тоо толгойн албан татвар 17,8 мянга, газрын төлбөр 1206,9 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 2580,6 мянган ,иргэний орлого тодорхойлох хуудасаар 6989,2 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод сумын Засаг даргын Тамгын газар 1000.0 мянган төгрөгийн орлогоос 1030 мянган төгрөгийн орлого оруулж 30,0 мянган төгрөгөөр давуулсан байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 25000,0 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 29338,4 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

### 3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 1161030,0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 998040,5 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас мянган төгрөгийг 895740,5 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж 102300,0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Заг сумын Засаг дарга	1161030,6	998040,5	162990,1	86
2	70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	80721,5	69305,3	11416,2	85,8
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	5700,0	5700	0	100
4	70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	320180,7	308200,5	11980,2	96
5	80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал	58613,5	55803,0	2810,5	95
6	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	12500,0	12494,3	5,7	100
7	80815 Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн	14373,3	14353,3	20	100.0
8	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	50000,0	48082,0	1918	96
9	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал	88000,0	80730,9	7270	92
10	82212 хур хог хаягдал, орчны бохирдол	6000,0	5996,6	0,4	100
11	Гамшгаас сэргийлэх сургалт сурталчилгаа				
12	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	39066,0	37415,3	1651	96
13	71702 Соёл урлаг	47003,1	46002,5	1000,6	98
14	71801 Сургуулийн өмнөх боловсрол	34085,7	28373,9	5711,7	83
15	71802 Ерөнхий боловсрол	121703,8	95832,9	25870,8	79
16	70503 Орон нутгийн зорилтот орон оруулалт	20870,8	10000	10870,8	48
17	83401 ОНХС-Итгэлцүүрээр тооцох	112852,1	87300,0	25552,1	77
18	73402 ОНХС-хайгуулийн тусгай зөвшөөрлийн төлбөр				
19	83405 ОНХС Малын тоо толгойн албан татвар	20000,0	0	20000,0	0
20	83406 ОНХС -бусад	22860,1	5000,0	746,4	22
21	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	106500,0	87450,0	19050,0	82
	<b>Нийт дүн</b>	<b>1161030,6</b>	<b>998040,5</b>	<b>162990,1</b>	<b>86</b>

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021.12.20-ний өдрийн 5/10 дугаар тогтоолоор нийт 1214015,4 мянган төгрөгөөр баталсан байна.

*Хүснэгт №14. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/*

Заг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	66948,0	84099,9	17151,9
Засаг даргын Тамгын газар	613657,9	551826,0	-61831,9
Сургууль	156935,6	156935,6	0,0
Цэцэрлэг	54046,2	54046,2	0,0
Эрүүл мэндийн төв	39066,0	39066,0	0,0
Соёлын төв	44958,7	44958,7	0,0
Сум хөгжүүлэх сан		106500,0	106500
Орон нутгийн хөгжлийн сан		176583,0	176583
<b>Нийт дүн</b>	<b>975612,4</b>	<b>1214015,4</b>	<b>238403,0</b>

Эх сурвалж: Заг сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2021.12.20-ний өдрийн 5/10 дугаар тогтоолоор анх 1214015,4 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2022.06.16-ний өдрийн 06/09 дугаар тогтоолоор 52948,8 мянган төгрөгөөр бууруулж 1161030,6 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 135712,2 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 515807,6 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 165300,0 мянган төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 22500,0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 321710,8 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгаас авсан санхүүгийн дэмжлэг 497107,6 мянга, орон нутгийн орлогоос 727659,9 орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс 134965,8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 31368,4 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 1030,0 мянган төгрөгийн санхүүжилт авч 62312,1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОН
ЗДТГ	549667,5	525660,2	24007,3	96	380840,0
ИТХ	86421,5	75005,3	11416,2	87	0
Соёлын төв	47003,1	46002,5	1000,6	98	0
Сум хөгжүүлэх сан	106500,0	87450,0	19050,0	82	-
Сургууль	121703,8	95832,9	25870,9	79	0
Цэцэрлэг	34085,7	28373,9	5711,8	83	0
ЭМТ	39066,0	37415,3	1650,7	96	0
ОНХС	176583,0	102300,0	74283,0	58	40870,8
<b>Нийт дүн</b>	<b>11161030,6</b>	<b>998040,5</b>	<b>162990,1</b>	<b>86</b>	<b>421710,8</b>

Эх сурвалж: Заг сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 86 хувьтай байгаа нь ЗДТГ-ын урсгал зардлыг 24007,3 мянга, ИТХ-ын урсгал зардлыг 11416,2 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 74283,0 мянга, Сургуулийн байр ашиглалтын зардлаас 25870,9 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Заг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 11717,0 мянга, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 2840,4 мянга, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 27742,3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 38242,3 мянган төгрөгийг зарцуулж 4057,0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	НИЙТ
<b>НИЙТ ОРЛОГО</b>	1,300.0	40999,3	42299,3
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,300.0	10417	11717,0
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2840,4	2840,4
Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		27742,3	27742,3
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	1,300.0	40999,3	42299,3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,300.0	36942,3	38242,3
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		4057,0	4057,0
<b>Төсөвт төвлөрүүлсэн</b>	0.0	0.0	0.0

*Эх сурвалж: Заг сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 103 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 86.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна..

Заг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайланд толилууаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Заг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 4 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна

**Заг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Төрийн аудитын байгууллагаас Заг сумын Засаг даргын харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулан санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна.

*Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн*

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл				
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Үүнээс			
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Зөрчилгүй	Хязгаарлагдтай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан
ЗДТГ	1	1		1					
ИТХурал	1	1		1					
ОНХС	1	1		1					
СХС	1	1		1					
<b>НИЙТ ДҮН</b>	<b>4</b>	<b>4</b>		<b>4</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>		<b>0</b>

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл*

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 38,923.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд зөрчил давтан гаргахгүй байх зөвлөмж өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн*

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
			Залруулга		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн зөрчил										
ЗДТГ	1	3,678.0							1	3,678.0
ОНХСан	1	36,145.4							1	36,145.4
СТА зөрчлийн дүн	2	39823.4	0	0	0	0	0	0	2	39823.4
СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал										
ЗДТГ	0	0								
НХСан	0	0								
Нийцлийн аудитын дүн	0	0								
Нийт дүн	2	39,823.4							2	39,823.4

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн*

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 152 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээллийн хугацаа болоогүй байна.

*Хүснэгт 19. Шилэн дансны мэдээлэл*

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	14	14	11	1	2
2	Хагас жил	3	3	3		
3	Улирал бүр	2	8	8		
4	Сар бүр	5	60	60		
5	Тухай бүр	6	72	70	2	
	Нийт	30	157	152	3	2

*Эх сурвалж. Заг сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас*

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг хуулийн хэрэгжилтийг Заг сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад дараах зөрчил илрээгүй байна.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 алдаа, зөрчил илэрснээс алдаа, зөрчил давтан гаргахгүй байх н 4 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 15-ний өдрийн 3/108 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

*Хүснэгт 20* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт							
Зөвлөмж	4	0	4	0			100.0
Нийт	4	0	4	0			100.0

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил давтан гаргахгүй байх 15,859.9 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 15,859.9 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өгч, зөрчил давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлээ.

#### 4.1.1 Албан шаардлага

Малын тоо толгойн албан татварын орлогоор тайлант онд 37,172.9 мянган төгрөг төвлөрүүлэхээр ногдуулалт хийсэн байхад 21,313.0 мянган төгрөг төвлөрүүлж 15,859.9 мянган төгрөг дутуу төвлөрүүлсэн

**Шийдвэрлэсэн нь:** Малын тоо толгойн албан татварын 15,859.9 мянган төгрөгийн дутуу төвлөрсөн албан татварын орлогыг бүрэн төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэв.

#### 4.2.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛТАЙ ХОЛБООТОЙ

Илрүүлэлт: Заг сумын Засаг даргын тайланд нэгтгэгддэг төсөвт байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 39,823.4 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрсэн байна.

Өгсөн зөвлөмж: Өөрийн харьяанд нэгтгээгддэг төсвийн шууд захирагчдын Нягтлан бодох бүртгэлийн тайлагнал, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

##### 5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Заг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:
2022			БНА-2023/4/НА-СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Заг сумын Засаг дарга	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар:					
1	Малын тоо толгойн албан татварын орлогоор тайлант онд 37,172.9 мянган төгрөг төвлөрүүлэхээр ногдуулалт хийсэн байхад 21,313.0 мянган төгрөг төвлөрүүлж 15,859.9 мянган төгрөг дутуу төвлөрүүлсэн	15,859.9	Албан шаардлага өгөв.	Төсвийн захирагч, Санхүүгийн албан дарга	Т.Нямжаргал, Д.Дуламсүрэн
2	Заг сумын Засаг даргын тайланд нэгтгэгддэг төсөвт байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 39,823.4 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрсэн байна.	0	Зөвлөмж өгөв.	Төсвийн захирагч, Санхүүгийн албан дарга	Г.Доржбат, Б.Анхбаяр
<b>ДҮН</b>		15,859.9			

оОо